

БАТЛАВ:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН
ТӨВИЙН ЗАХИРАЛ

Ч.БАТ-ЭРДЭНЭ



“ҮНДЭСНИЙ ҮНЭТ ЦААС” ХХК-ИЙН
ДЭД ЗАХИРАЛ



Б.АЛЕКСАНДР

**ЭМ, ОНОШЛУУР, БИОЛОГИЙН ИДЭВХИТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ
БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ ХЭВЛҮҮЛЭХ ГЭРЭЭ**

2016.11.29 №52

2016.11.22

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээг нэг талаас Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эмийн зохицуулалтын албаны дарга Д.Бямбадорж /цаашид захиалагч тал гэх/, нөгөө талаас “Үндэсний үнэт цаас” ХХК - ийг төлөөлж Эдийн засагч Ч.Шинэтуяа /цаашид гүйцэтгэгч тал гэх/ нар Монгол улсын “Иргэний тухай”, “Үнэт цаасны тухай” хуулийн хүрээнд дараах зүйлийг харилцан тохиролцож байгуулав.

Хоёр. Талуудын эрх, үүрэг

2.1. Захиалагч талын эрх, үүрэг

2.1.1. Эмийн бүртгэлийн гэрчилгээг /цаашид гэрчилгээ гэх/ эх бэлтгэлийн загварын дагуу нийт 500 ширхэгийг хэвлүүлнэ.

2.1.2. Захиалагч тал хэвлэгдэн гарсан гэрчилгээг ажлын 3 хоногт багтаан хүлээн авна.

2.1.3. Гэрчилгээний нэг бүрийн үнэ 1500 төгрөг байх бөгөөд нийт НӨАТ 10% - ийн хамт 1650 төгрөг буюу нийт 825000 төгрөг (найман зуун хорин таван мянган) -ийг “Үндэсний үнэт цаас” ХХК - ийн Голомт банк - 1102596741 тоот дансанд гэрчилгээг хэвлүүлэн хүлээн авснаар шилжүүлнэ.

2.2. Гүйцэтгэгч талын эрх, үүрэг

2.2.1. Гүйцэтгэгч нь захиалсан гэрчилгээг эх бэлтгэлийн дагуу хэвлэнэ.

2.2.2. Бүтээгдэхүүний эх загварын бүрэн бүтэн байдлыг хариуцна.

2.2.3. Гэрчилгээг нууцлал, чанарын өндөр түвшинд гүйцэтгэнэ.

2.2.4. Гүйцэтгэгч нь гэрчилгээний захиалсан загварыг буруу хэвлэсэн тохиолдолд учирсан хохиролыг өөрийн зардлаар нөхөн хэвлэнэ.

2.2.5. Гүйцэтгэгч гэрчилгээг захиалсан өдрөөс эхлэн ажлын 3 хоногт багтаан хэвлэж захиалагчид хүлээлгэн өгнө.

Гурав. Бусад

3.1. Талууд гэрээний нөхцлүүдийг зохих ёсоор биелүүлээгүй бол хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

3.2. Гэрээний явцад үүссэн маргааныг талууд зөвшилцлийн замаар шийдвэрлэх бөгөөд эс зөвшөөрвөл хууль тогтоомжид заасны дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

3.3. Гэрээг талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр өөрчилж, цуцалж, дуусгавар болгоно.

3.4. Талууд гэрээнд гарын үсэг зурж, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.

3.5. Энэхүү гэрээг 2 хувь үйлдэх бөгөөд хууль зүйн хувьд тус бүр адил хүчинтэй байна.

Гэрээ байгуулсан:

Эрүүл мэндийн хөгжлийн төв

Энхтайваны гудамж 13/б

Эмийн зохицуулалтын албаны дарга



Д.Бямбадорж


Утас: 70128804

“Үндэсний үнэт цаас” ХХК

Чингэлтэй дүүрэг 1-р хороо

Жуулчны гудамж 10/1

Эдийн засагч



Ч.Шинэтуяа

Утас: 327102, 327115